



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2020 оны 08 сарын 28 өдөр

Дугаар 9

Мандалговь

Ц.Живаа, Б.Эрдэнэтуяа нарыг шагналд
нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 71 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны тэргүүний ажилтан” цол тэмдгээр шагнах журмын 3 дугаар бүлгийн 3.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2020 оны 2 дугаар сарын 19-ны өдрийн 2 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Төрийн албанд олон жил идэвх санаачлагатай, үр бүтээлтэй ажиллаж, орон нутагт төр засгийн бодлого шийдвэр, төрийн албаны шинэтгэлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулж, үр дүн гаргаж байгаа Сайнцагаан сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга Б.Эрдэнэтуяа, Цагаандэлгэр сумын ЗДТГ-ын ахмад ажилтан Ц.Живаа нарыг “Төрийн албаны тэргүүний ажилтан” цол, тэмдгээр шагнуулахаар Төрийн албаны зөвлөлд уламжилсугай.

Хоёр. Б.Эрдэнэтуяа, Ц.Живаа нарын шагналын материалыг журмын дагуу бүрдүүлж, Төрийн албаны зөвлөлд хүргүүлэхийг Салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Ц.ЭРДЭНЭСҮРЭН

